



**ГОЛДЕН ПЭЙЖ АУДИТ ХХК**

**“ЖИДАКС” ХК**

**САНХҮҮГИЙН ТАЙЛАН, АУДИТОРЫН ДҮГНЭЛТ**

**2023 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон  
санхүүгийн тайлангийн аудит**

**Улаанбаатар хот. 2024 он**

# ГОЛДЕН ПЭЙЖ АУДИТ ХХК

Нягтлан бодох бүртгэл, татварын зөвлөх үйлчилгээ  
2705958, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 6-р хороо  
Метро бизнес төв А корпус 8 давхар  
Утас факс: 99170900, 70117179  
Email: info@goldenpageaudit.mn

2024.02.19 № А/04

танаа \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

## ЖИДАКС ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД

### ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Бид “Жидакс” ХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-нээрх Санхүүгийн Байдлын Тайлан, тайлант жилийн Ашиг, Алдагдал болон Бусад Дэлгэрэнгүй Орлогын Тайлан, Өмчийн Өөрчлөлтийн Тайлан, Мөнгөн Гүйлгээний Тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, бусад тайлбар тодруулгуудад аудит хийж гүйцэтгэлээ.

#### Дүгнэлт

Бидний дүгнэлтээр, эдгээр санхүүгийн тайлангууд нь бүхийл материаллаг талаараа “Жидакс” ХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдал, тухайн жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартуудын дагуу, Сангийн яамнаас баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-ууд болон Монгол улсад мөрдөгдөж буй холбогдох хууль, тогтоомжуудын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа энэ тайлангийнхаа Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага гэсэн хэсэгт харуулав.

Бид санхүүгийн тайлангийн энэхүү аудитын ажилд хамаарах ёс зүйн шаардлагуудын дагуу байгууллагаас хараат бус ба эдгээр шаардлагуудын дагуух ёс зүйн бусад үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно.

Олж авсан аудитын баримт нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай, тохиромжтой гэж итгэж байна.

#### Удирдлага болон засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайлагналын олон улсын стандартуудын дагуу эдгээр санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээх бөгөөд мөн залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.



Санхүүгийн тайланг гаргахдаа удирдлага байгууллагын үйл ажиллагааг зогсоох юм уу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудаа гаргах тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах байгууллагын чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь байгууллагын санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

### Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ анги эсэх талаарх ул үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлдэг гэсэн нотолгоо болохгүй. Буруу илэрхийлэх явдал нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог.

Аудит нь санхүүгийн тайлангийн дүн болон тодруулгуудын талаарх аудитын нотолгоо олж авах зориулалтаар гүйцэтгэх горимуудыг багтаадаг. Сонгож авсан горимууд нь аудиторын үнэлэмжээс хамаарах бөгөөд үүнд залилан юмуу алдаанаас үүдэлтэй санхүүгийн тайлангийн материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийн үнэлгээ багтдаг. Эрсдэлийн энэхүү үнэлгээг хийхдээ аудитор аж ахуйн нэгжийн дотоод хяналтын үр ашигт байдлын талаар дүгнэлт гаргах зорилгоор бус тухайн нөхцөл байдалд тохирсон аудитын горимыг зохиох зорилготойгоор аж ахуйн нэгжийн санхүүгийн тайланг бэлтгэж, шударгаар толилуулахтай холбоотой дотоод хяналтыг авч үздэг.

### Тайлангийн хэрэглээ

Энэхүү тайланг Монгол Улсын “Компанийн тухай хууль”-ийн 95.1-р зүйлд заасны дагуу “Жидакс” ХК-ийн удирдлага болон эрх бүхий этгээдэд танилцуулахад зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй.

  
УГААНБААТАР ХОЗ  
**ГОЛДЕН ПЭЙЖ  
АУДИТ  
ХХК**  
С.Оюунгэрэл  
Захирал МНБ  
УЗМ03148 2705958  
Голден пэйж Аудит ХХК

Огноо: 19/II 242

  
**ГОЛДЕН ПЭЙЖ  
АУДИТ ХХК**  
хуудас 2

**ЖИДАКС ХК**  
**GDACS JSC**

Улаанбаатар хот, Баянгол дүүрэг,  
16-р хороо, "Шинэ Монгол хаад групп"-ын  
2 давхарт  
Утас: 7011-9877, 91993560  
И-мэйл: official@gdacs.mn


**“Голден Пэйж Аудит” ХХК-д**

Огноо 2024.02.19 № 2402/01  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Гүйцэтгэх удирдлагын мэдэгдэл**

Гүйцэтгэх захирал Lee овогтой Jeoung Но би “Жидакс” ХК-ийн гүйцэтгэх удирдлагын хувьд, ерөнхий нягтлан бодогч Дорлигжав овогтой Болормаа би гүйцэтгэх удирдлагын хувьд ард хавсаргасан 1-ээс ..... хуудас дахь “Жидакс” ХК-ийн санхүүгийн тайлангуудыг холбогдох Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэсэн бөгөөд 2023 оны 12-р сарын 31-нээрх уг өдрөөр тасалбар болгосон санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон холбогдох тодруулгуудыг шударгаар үзүүлж байна гэдгийг үүгээр мэдэгдэж байна. Энэхүү тайланг хүлээн зөвшөөрч батлав.

Гүйцэтгэх захирал  
  
Lee Jeoung Ho/  
9021070259  
2049929-СБТ15568  
УЛААНБААТАР ХОТ

Ерөнхий нягтлан бодогч  
  
/Д.Болормаа/

**ГОЛДЕН ПЭЙЖ**  
**АУДИТ ХХК**  
хуудас **3**

"ЖИДАКС" ХК  
АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН  
2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НЭЭРХ

(төгрөгөөр)

ХӨРӨНГӨ	Үзүүлэлт	Тодруулга	2022.12.31	2023.12.31
<b>1.Эргэлтийн хөрөнгө</b>				
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө		4	11,401,645	3,053,239
Татвар, НДШ-ийн авлага		5	3,679,323	3,887,006
Бусад авлага		6	268,837,420	302,237,420
Урьдчилж төлсөн зардал/гооцоо		7	1,942,700	48,117,182
<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>			<b>285,861,088</b>	<b>357,294,847</b>
<b>2.Эргэлтийн бус хөрөнгө</b>				
Үндсэн хөрөнгө		8	141,719,200	99,537,000
Биет бус хөрөнгө		9	31,209,500	31,157,866
Урт хугацаат хөрөнгө оруулалт		10	3,741,971,580	3,705,071,580
<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>			<b>3,914,900,280</b>	<b>3,835,766,446</b>
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>			<b>4,200,761,368</b>	<b>4,193,061,293</b>
<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ</b>				
<b>1.Богино хугацаат өр төлбөр</b>				
Татварын өр		11	111,762	774,105
Банкны богино хугацаат зээл		13	25,000,000	4,000,000
Бусад богино хугацаат өр төлбөр		12	101,772,424	128,341,204
Урьдчилж орсон орлого				28,351,591
<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>			<b>126,884,186</b>	<b>161,466,900</b>
<b>2.Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>				
Урт хугацаат зээл		14	2,847,235,882	2,847,235,882
<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>			<b>2,847,235,882</b>	<b>2,847,235,882</b>
<b>Өр төлбөрийн дүн</b>			<b>2,974,120,068</b>	<b>3,008,702,782</b>
<b>Эзэмшигчийн өмч</b>				
Өмч: -Төрийн			-	-
-Хувийн		15	1,373,575,194	1,373,575,194
Халаасны хувьцаа			3,269,700	3,269,700
Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг			1,029,200	1,029,200
Хуримтлагдсан ашиг /алдагдал/			(151,232,794)	(193,515,583)
<b>Эзэмшигчдийн өмчийн дүн</b>			<b>1,226,641,300</b>	<b>1,184,358,511</b>
<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>			<b>4,200,761,368</b>	<b>4,193,061,293</b>

Хавсаргасан тэмдэглэлүүд нь энэхүү тайлангийн саллигүй хэсэг болно.



**"ЖИДАКС" ХК**  
**АУДИТ ХИЙГДСЭН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН**  
**2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НЭЭРХ**  
**(төгрөгөөр)**

	Тодруулга	2022.12.31	2023.12.31
Борлуулалтын орлого			
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг			
<b>Нийт ашиг (алдагдал)</b>			
Түрээсийн орлого			
Хүүний орлого			346
Ерөнхий ба удирдлагын зардал	19	56,748,512	
Бусад зардал	17	14,551,272	
Гадаад валютын ханшийн зөрүүний олз /гарз/	16	3,513,598	(100,900)
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз /гарз/			
Биет бус хөрөнгө данснаас хассаны олз /гарз/			(42,182,200)
Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз /гарз/			
Бусад ашиг /алдагдал/			
<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>		<b>(67,786,186)</b>	<b>(42,282,754)</b>
Орлогын татварын зардал	18		35
Хойшлогдсон татварын зардал /орлого/			
<b>Татварын дараах ашиг /алдагдал/</b>		<b>(67,786,186)</b>	<b>(42,282,788)</b>
Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг /алдагдал/			
<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал )</b>		<b>(67,786,186)</b>	<b>(42,282,788)</b>
Бусад олз /гарз/			
<b>Орлогын нийт дүн</b>		<b>(67,786,186)</b>	<b>(42,282,788)</b>

*Хавсаргасан тэмдэглэлүүд нь энэхүү тайлангийн салсгүй хэсэг болно.*



**"ЖИДАКС" ХК**  
**АУДИТ ХИЙГДСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**  
**2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НЭЭРХ**  
 (төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмч	Халаасны хувьцаа	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,373,575,194</b>	<b>3,269,700</b>	<b>1,029,200</b>	<b>(76,907,208)</b>	<b>1,294,427,486</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					-
<b>Залруулсан үлдэгдэл</b>				<b>(67,786,186)</b>	<b>(67,786,186)</b>
Тайлант үеийн цэвэр ашиг					-
Бусад дэлгэрэнгүй орлого					-
Өмчит гарсан өөрчлөлт					-
Зарласан ноогдол ашиг					-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн					-
<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,373,575,194</b>	<b>3,269,700</b>	<b>1,029,200</b>	<b>(144,693,394)</b>	<b>1,226,641,300</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					-
<b>Залруулсан үлдэгдэл</b>				<b>(42,282,788)</b>	<b>(42,282,788)</b>
Тайлант үеийн цэвэр ашиг					-
Бусад дэлгэрэнгүй орлого					-
Өмчит гарсан өөрчлөлт					-
Зарласан ноогдол ашиг					-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн					-
<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,373,575,194</b>	<b>3,269,700</b>	<b>1,029,200</b>	<b>(186,976,183)</b>	<b>1,184,358,511</b>



"ЖИДАКС" ХК  
АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН  
2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НЭЭРХ  
(төгрөгөөр)

Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31
<b>1. Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>		<b>28,351,591</b>
Бусад мөнгөн орлого		28,351,591
<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>69,412,240</b>	<b>31,399,443</b>
Ажиллагчдад төлсөн	25,422,784	20,750,732
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	6,089,570	7,016,624
Бараа материал худалдан авахад төлсөн		27,720
Ашиглалтын зардалд төлсөн	1,143,086	185,600
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	7,311,328	27,275
Татварын байгууллагад төлсөн	2,534,565	1,786,369
Бусад мөнгөн зарлага	26,910,908	1,605,123
<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(69,412,240)</b>	<b>(3,047,852)</b>
<b>2. Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>213,000,000</b>	<b>42,900,345</b>
Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	-	36,900,000
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	213,000,000	6,000,000
Хүлээн авсан хүүний орлого		345
<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>779,561,980</b>	<b>48,400,000</b>
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	501,906,080	-
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	277,655,900	48,400,000
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(566,561,980)</b>	<b>(5,499,655)</b>
<b>3. Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>53,702,445</b>	<b>21,300,000</b>
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	53,702,445	21,300,000
<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>-</b>	<b>21,000,000</b>
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		21,000,000
<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>53,702,445</b>	<b>300,000</b>
Валютын ханшийн зөрүү	3,513,598	(100,900)
<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(578,758,177)</b>	<b>(8,348,406)</b>
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>590,159,822</b>	<b>11,401,645</b>
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>11,401,645</b>	<b>3,053,239</b>

Хавсаргасан тэмдэглэлүүд нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно.





## 1. Тайлагнагч аж ахуйн нэгж

Жидакс ХК (цаашид “Компани” гэх) нь Монгол улсад бүртгэлтэй, тус улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаагаа явуулдаг. Компанийг “Хувьцаат Компани” хэлбэртэйгээр Монгол Улсын Компаний тухай хуулийн дагуу 2013 онд үүсгэн байгуулсан. Компани нь Монгол улсад Улаанбаатар хотын Баянгол дүүрэг 16-р хороо, орхон 1, Шинэ монгол хаад групп ХХК-ийн байр 2 давхарт бүртгэлтэй.

Компани нь программ хангамжийн үйл ажиллагаа, мэдээлэл технологийн үйл ажиллагаа, вэб сайтын үйлчилгээ, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, онлайн худалдаа, авто машинаар ачаа тээвэрлэх үйл ажиллагаа эрхлэхээр бүртгүүлсэн.

Компани нь Монголын Хөрөнгийн Биржид бүртгэлтэй 13,735,752 ширхэг хувьцаатай, нээлттэй хувьцаат компани бөгөөд 2013 оны 07 дүгээр сарын 23-ны өдөр улсын бүртгэлд бүртгүүлж 9010001138 тоот дугаар бүхий, 2049929 тоот регистрийн дугаартай гэрчилгээтэй.

## 2. Тайлагналын үндэслэл

Санхүүгийн тайлангуудыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартад нийцүүлэн Монгол Улсын Санхүү Эдийн Засгийн сайдын 2002 оны 171/111 болон 191 тоот тушаалаар баталсан аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт маягт, журнал, бүртгэлийн системийн маягтын дагуу бүртгэл хөтөлж, Сангийн сайдын 2017 оны 361-р тушаалаар баталсан санхүүгийн тайлангийн маягт, хавсралтын дагуу тайланг бэлтгэдэг.

Компанийн удирдлага энэхүү санхүүгийн тайлангуудыг тасралтгүй байх зарчимд үндэслэн бэлтгэсэн болно.

Санхүүгийн тайлангуудыг Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулинд зааснаар Монгол Улсын мөнгөн тэмдэгт Төгрөгөөр илэрхийлсэн байна.

## 3. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого

Жидакс ХК-д тусгайлан боловсруулсан нягтлан бодох бүртгэлийн баримт бичиг байхгүй байна. Компани Сангийн Яамнаас гаргасан нягтлан бодох бүртгэлийн заавар, арга аргачлал, СТОУС-ыг хэрэгжүүлэн санхүүгийн тайлангаа бэлтгэж байна.

**Санхүүгийн хэрэглүүр** -Санхүүгийн хэрэглүүрүүдийн ангиллаас хамааран бодит үнэ цэнэ эсвэл хорогдуулсан өртгөөр дор тайлбарласны дагуу бүртгэлд тусгадаг.

Бодит үнэ цэнэ нь зах зээлд оролцогчдын хооронд хөрөнгө худалдах эсвэл өр төлбөр барагдуулах гүйлгээг хэмжилтийн огноогоор зохион байгуулалттай явуулахад авах үнэ юм. Бодит үнэ цэнийн хамгийн тод жишээ бол идэвхтэй зах зээл дээрх үнэ юм. Идэвхтэй зах зээл гэдэг нь хөрөнгө болон өр төлбөрийн хэлцлүүд нь үнийн мэдээллээр тогтмол хангахуйц түвшинд явагддаг зах зээлийг хэлнэ.

Хорогдуулсан өртөг нь санхүүгийн хэрэглүүрүүдийг анх хүлээн зөвшөөрсөн дүнгээс аливаа үндсэн дүнгийн эргэн төлөлтийг хасаж, хуримтлагдсан хүүг нэмж, санхүүгийн хөрөнгийн хувьд үнэ цэнийн бууралттай холбоотой аливаа хасагдуулгыг хассан дүн юм. Хуримтлагдсан хүүд анх хүлээн зөвшөөрөх үед хойшлогдсон гүйлгээний зардлын хорогдуулалт, мөн үнийн аливаа нэмэгдэл буюу хөнгөлөлтийн дүнгийн үр ашигт хүүгийн аргаар тооцсон хорогдуулалт орно.

Хуримтлагдсан хүүгийн орлого, хуримтлагдсан хүүгийн зардал, мөн хуримтлагдсан купон болон үнийн хорогдуулсан нэмэгдэл буюу хөнгөлөлтийг (мөн аливаа хойшлогдсон шимтгэлийн хамт) тусад нь толилуулаагүй ба тэдгээрийг санхүүгийн байдлын тайлан дахь тэнцэлд хамаарах хэсэгт бүртгэлийн үнээр тусгасан болно.

Үр ашигт хүүгийн арга нь хүүгийн орлого эсвэл хүүгийн зардлыг хамаарах хугацааны туршид дансны үнээс тооцогдох хүүгийн хувийг тогтмол байлгахар (үр ашигт хүүгийн хувь) хуваарилах арга юм. Үр ашигт хүүгийн хувь нь ирээдүйд орж ирэхээр тооцоолсон мөнгөн орлого, гарах зарлагыг (ирээдүйн зээлийн алдагдлыг үл харгалзан) санхүүгийн хэрэглүүрийн хүлээгдэж буй хугацааны эсвэл зохистой бол түүнээс богино хугацааны туршид хямдруулж санхүүгийн хэрэглүүрүүдийн бүртгэлийн цэвэр дүнг гаргаж авах хүүгийн хувь болно.

**Санхүүгийн хэрэглүүрийн ангилал.** Санхүүгийн хөрөнгийг дараах байдлаар ангилна: (а) зээл болон авлага; (б) борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө; (в) дуусгавар хугацаа хүртэл эзэмших санхүүгийн хөрөнгө (г) бодит үнэ цэнээр илэрхийлэгдэх санхүүгийн хөрөнгө.

Бодит үнэ цэнээр илэрхийлэгдэх санхүүгийн хөрөнгийг дотор нь 2 ангилдаг: (а) анх хүлээн зөвшөөрөх үед ийнхүү ангилагдсан, ба (б) борлуулах зорилгоор эзэмшиж байгаа.

**Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө.** Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгөнд касс дахь бэлэн мөнгө, мөн анх гурван сар буюу түүнээс бага хугацаатай байршуулсан хугацаатай хадгаламж болон хугацаагүй хадгаламж (бодит үнэ цэнийн өөрчлөлтийн эрсдэл багатай) орно. Компани нь богино хугацаат өр төлбөрийг удирдах зорилгоор эдгээрийг ашигладаг.

**Дансны болон бусад авлага.** Дансны болон бусад авлагыг үр ашигт хүүгийн аргыг ашиглан хорогдуулсан өртгөөр бүртгэнэ.

**Урьдчилж төлсөн зардал.** Өртгөөс үнэ цэнийн бууралтын нөөцийг хассан дүнгээр урьдчилж төлсөн зардлыг бүртгэнэ. Хэрэв урьдчилгааг нь төлсөн бүтээгдэхүүн эсвэл үйлчилгээг нэг жилийн дараа хүлээн авахаар бол эсвэл урьдчилгаа нь төлөгдсөн хөрөнгө өөрөө анхны хүлээн зөвшөөрөлтөөрөө эргэлтийн бус хөрөнгөнд ангилагдахаар бол урьдчилгааг эргэлтийн бус хөрөнгө гэж бүртгэнэ. Компани тухайн хөрөнгийг хянан зарцуулахаас гадна тухайн хөрөнгөтэйгөөр холбогдсон ирээдүйн эдийн засгийн үр өгөөжийг хүртэх магадлалтай болмогц хөрөнгө худалдан авахаар төлсөн урьдчилгаа төлбөрийг хөрөнгийн дансны үнэ рүү шилжүүлнэ. Бусад урьдчилгаа төлбөрийг тухайн урьдчилж төлсөн зардалд хамаарах бүтээгдэхүүн эсвэл үйлчилгээг хүлээн авсан үедээ ашиг, алдагдал руу хааж бичнэ.

Хэрэв урьдчилгаа хийгдсэн хөрөнгө, бүтээгдэхүүн эсвэл үйлчилгээг хүлээн авахгүй нь тодорхой болвол тухайн урьдчилгааг бүртгэлийн үнээр нь данснаас хасч түүнтэй холбоотой үнэ цэнийн бууралтыг тухайн тайлант хугацааны ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

**Бараа материал.** Бараа материалыг анх өртгөөр нь үнэлж бүртгэх бөгөөд дараа үед өртөг болон цэвэр боломжит үнийн аль багаар үнэлж тайлагнана. Бараа материалын өртөгт худалдан авалтын өртөг, хувиргалтын зардал болон одоогийн нөхцөлд авч ирэх хүртэлх зардлыг оруулна.

Цэвэр боломжит үнийг тооцохдоо бизнесийн ердийн үйл ажиллагааны явцад борлуулахаар тооцсон үнээс тухайн барааг бүрэн үйлдвэрлэж дуусгахад шаардагдах өртөг ба борлуулалтын зардлыг хасч тооцно. Бараа материалыг цэвэр боломжит үнэ хүртэл бууруулах дүн болон бараа материалын бүх төрлийн хорогдлыг гарсан тухайн тайлант хугацааны зардлаар бүртгэнэ. Цэвэр

боломжит үнэ цэнийн өсөлтөөс үүдэн өмнө бараа материалыг бууруулсан бичилтээ буцаах бол буцаалт хийгдэх тайлант хугацаанд зардлаар бүртгэсэн дүнг бууруулах зарчмаар бүртгэнэ.

**Өмч, барилга, тоног төхөөрөмж.** Өмч, барилга, тоног төхөөрөмжийг өртгөөс нь хуримтлагдсан элэгдэл ба үнэ цэнийн бууралтын нөөцийг хассан дүнгээр тусгадаг.

Өмч, барилга, тоног төхөөрөмжийн үнэ цэнэ буурсан шинж тэмдэг илэрсэн эсэхийг удирдлага тайлант үе бүрийн эцэст үнэлдэг. Ийм шинж тэмдэг илэрсэн тохиолдолд удирдлага хөрөнгийн бодит үнэ цэнээс борлуулах өртгийг хассан дүн болон түүний ашиглалтын үнэ цэнийн аль ихээр нь нөхөх өртгийг тооцож, дансны үнийг нөхөх өртөг хүртэл бууруулж, гарзыг тухайн жилийн орлого, зардалд бүртгэдэг.

Өмч, барилга, тоног төхөөрөмж борлуулсны олз, гарзыг тодорхойлохдоо борлуулалтаас олсон орлогыг дансны үнэтэй харьцуулж тооцох бөгөөд олз, гарзыг тухайн жилийн орлого, зардалд бүртгэнэ.

**Элэгдэл.** Газрын сайжруулалт, барилга, машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, тээврийн хэрэгсэл, компьютер, дагалдах хэрэгслийн элэгдлийг тооцохдоо шулуун шугамын аргыг ашиглан түүний өртөг эсвэл дахин үнэлсэн дүнг тооцоолсон ашиглалтын хугацаанд хуваарилж үлдэх өртөг хүртэл нь элэгдүүлнэ:

Ашиглалтын хугацаа (жилээр)

Барилга	25 жил
Машин тоног төхөөрөмж	3-10 жил
Тээврийн хэрэгсэл	10 жил
Компьютер, дагалдах хэрэгсэл	2 жил

Хөрөнгийн үлдэх өртөг гэдэг нь хөрөнгө хуучирсан, ашиглагдах хугацаа нь дуусч буй гэж үзвэл Компани хөрөнгийг яг одоо борлуулснаас олох боломжтой үнээс борлуулалтын зардлыг хассан дүнг хэлнэ. Хөрөнгийн үлдэх өртөг, ашиглагдах хугацааг тайлант үе бүрийн эцэст эргэн харж шаардлагатай гэж үзвэл тохируулга хийнэ.

Анхдагч хүлээн зөвшөөрөлтийн дараа гарсан зардал нь Компанид орох эдийн засгийн өгөөжийг нэмэгдүүлж байвал мөн холбогдох дүнг бодитойгоор тооцоолох боломжтой бол хөрөнгийн дансны үнэд оруулан капиталжуулж болно. Бусад тохиолдолд уг зардлыг гарсан тайлант хугацаанд нь зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэнэ.

**Биет бус хөрөнгө.** Тусад нь худалдаж авсан биет бус хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөхдөө өртгөөр нь хэмжинэ. Анх хүлээн зөвшөөрч бүртгэсний дараа тэдгээрийг өртгөөс хуримтлагдсан хөрөгдөл (ашиглалтын хугацаа нь тодорхой хөрөнгийн хувьд) болон хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын гарзыг хассан дүнгээр хэмжинэ. Худалдан авсан программ хангамж, зохиогчийн эрх, патент бүртгэсэн байна.

Эдийн засгийн өгөөж нь өртгөөсөө давах магадлалтай байвал Компанийн эзэмшилд буй бие даасан тусгай программ хангамжтай шууд холбоотой гарсан тодорхойлох боломжтой хөгжүүлэлтийн зардлыг биет бус хөрөнгөөр бүртгэнэ. Капиталжуулах зардалд программ хөгжүүлэх багийн ажилтнуудын зардал, мөн нэмэлт зардлуудаас ногдох хувийг оруулна.

Программ хангамжтай холбоотой гарсан засвар үйлчилгээний гэх мэт бусад бүх зардлыг гарсан тухайн үед нь зарлагадна.

Биет бус хөрөнгийг ашиглахад бэлэн болсон өдрөөс нь хорогдуулж эхэлнэ. Биет бус хөрөнгийг тэдгээрийн ашиглалтын хугацаанд шулуун шугамын арга ашиглан хорогдуулах бөгөөд ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайланд тусгана. Дараах тооцоолсон ашиглалтын хугацаатай байна:

Ашиглалтын хугацаа(жилээр)	
Программ хангамж	3 жил
Зохиогчийн эрх	10 жил
Патент	10 жил

**Дансны болон бусад өглөг.** Дансны өглөгийг нөгөө тал гэрээнд заасан үүргээ биелүүлсэн үед хуримтлуулан бүртгэх ба худалдаа хийсэн өдрөөр анх хүлээн зөвшөөрнө. Худалдаа хийсэн өдөр гэж Компани тухайн хэрэглүүрийн гэрээний нөхцөлийг зөвшөөрч, гэрээ байгуулсан өдрийг хэлнэ. Компани гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэсэн, гэрээг цуцалсан буюу гэрээ хүчингүй болсон тохиолдолд санхүүгийн өр төлбөрийг данснаас хасна.

**Хувьцаат капитал.** Энгийн хувьцааг эзэмшигчдийн өмчид ангилдаг. Шинээр энгийн хувьцаа гаргахтай шууд холбогдон гарсан зардлыг өөрийн хөрөнгөөс хорогдуулж, татварын нөлөөг суутгасан цэвэр дүнгээр хүлээн зөвшөөрнө.

**Хөрөнгө ба өр төлбөрийг хооронд нь хаах.** Хүлээн зөвшөөрсөн дүнгүүдийг хооронд нь хаах хууль ёсны эрх үүссэн бөгөөд цэвэр дүнгээр нь төлбөр тооцоо хийх эсвэл хөрөнгө борлуулах, өр төлбөр барагдуулах ажиллагааг нэгэн зэрэг гүйцэтгэхээр зөрьж байгаа тохиолдолд л зөвхөн санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрийг хооронд нь хааж цэвэр дүнгээр санхүүгийн байдлын тайланд тайлагнана.

**Орлого хүлээн зөвшөөрөлт.** Борлуулсан аж үйлчилгээнээс орох орлогыг хүлээн авсан мөнгө, авлагын бодит үнэ цэнэд үндэслэн хэмжинэ.

Орлого нь хүлээн авсан, эсвэл хүлээн авахаар хүлээгдэж буй бодит үнэ цэнээр баталгаажуулж баримт нотолгоотой болсон, өмчлөлтэй холбоотой гол эрсдэл, өгөөж нь худалдан авагч талд шилжсэн, авлага төлөгдөх магадлалтай, орлогын дүнг найдвартай хэмжиж болох тохиолдолд хүлээн зөвшөөрдөг. Эрсдэл ба өгөөжийг шилжүүлэх хугацаа борлуулалтын гэрээний нөхцөлөөс хамаарч харилцан адилгүй байна.

**Санхүүгийн орлого, зардлын хүлээн зөвшөөрөлт:** Хүүгийн орлого, зардлыг бүх өрийн эсвэл хөрөнгө оруулалтын хэрэгсэлд аккруэл суурь дээр үндэслэн үр ашигт хүүгийн аргаар бүртгэнэ. Энэ аргын дагуу гэрээний талуудын хооронд төлөгдсөн бүх хураамж, гүйлгээний зардал болон бусад бүх үнийн нэмэгдэл буюу хөнгөлөлтийг үр ашигт хүүнд оруулан тооцож, цаг хугацааны хувьд койшлуулан хүүгийн орлого эсвэл зардалд бүртгэдэг.

Үр ашигт хүүгийн бүрэлдэхүүн хэсэг болох хураамжид санхүүгийн хөрөнгийг худалдан авах эсвэл санхүүгийн өр төлбөрийг үүсгэхэд шууд холбоотойгоор нэмэгдэн гардаг, жишээлбэл төлбөрийн чадварыг үнэлэх, зээлийн баталгаа эсвэл барьцааг үнэлэх болон бүртгэх, хэрэгслийн нөхцөлүүдийг хэлэлцэх болон холбогдох баримт бичиг боловсруулах зэрэг гэрээ

байгуулахтай холбоотой аливаа хураамжууд орно. Банк нь харилцагчид зээл олгосны дараах богино хугацаанд тухайн зээлийг худалдах магадлалтай тохиолдолд тухайн зээлийг зах зээлийн хүүгээр олгохтой холбоотой хураамж, шимтгэлийг үр ашигт хүүгийн бүрэлдэхүүн хэсэг болгон тооцно. Зээл олгохоор хүлээсэн үүргийг Банк ашиг алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжигдсэн санхүүгийн өр төлбөр гэж ангилдаггүй болно.

Зээл болон бусад өрийн хэрэгслүүд найдваргүй болсон үед тэдгээрийг хүлээгдэж буй мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнэ хүртэл бууруулж бүртгэх бөгөөд түүнээс хойш өнөөгийн үнэ цэнийн өсөлтийг тухайн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын гарзыг тооцоход ашигласан үр ашигт хүүгийн үндсэн дээр тооцоолж хүүгийн орлогоор бүртгэдэг.

Бусад хураамж шимтгэлүүдийг аккруэл сууриар хүлээн зөвшөөрч бүртгэх ба тайлант хугацаа хүртэлх хүлээн авсан эсвэл үзүүлсэн үйлчилгээг нийт хүлээн авах эсвэл үзүүлэх үйлчилгээнд нь харьцуулж гүйцэтгэлийн хувийг тооцоолно.

Хүүгийн орлогыг бусад орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэнэ.

**Гадаад валютын хөрвүүлэлт.** Компанийн бүртгэлийн ба толилуулгын валют нь Монгол Улсын мөнгөн тэмдэгт болох Монгол төгрөг юм. Гадаад валютаар хийсэн ажил гүйлгээг гүйлгээ хийгдсэн өдрийн ханшаар Компанийн бүртгэлийн валют руу хөрвүүлнэ. Гадаад валютаар бүртгэгдсэн мөнгөнд хөрвөх хөрөнгө ба өр төлбөрүүдийн тайлангийн өдрөөрх үлдэгдлийг уг өдрийн ханшаар бүртгэлийн валют руу хөрвүүлнэ. Хөрвүүлэлтээс үүссэн гадаад валютын ханшийн олз, гарзыг ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайланд тусгана.

**Татвар.** Ажиллагсдын цалингаас болон хувь хүнээр гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээнээс Хувь хүний орлогын албан татварыг суутган тооцож төлдөг. Жидакс ХК нь Аж ахуйн нэгж байгууллын албан татвар төлөгч, Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгч, Үл хөдлөх хөрөнгийн албан татвар төлөгч байгууллага юм.

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД

2023 оны 12 дугаар сарын 31-нээрх /төгрөгөөр/

### 4. Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө

Төрөл	Банк	Дансны дугаар	Валют	2022.12.31	2023.12.31
Касс			MNT		2,233,711
					<b>2,233,711</b>
Харилцах	Худалдаа хөгжлийн банк	90403002193	MNT	82,207	67,403
Харилцах	Худалдаа хөгжлийн банк	90403002193	USD	11,319,438	752,125
				<b>11,401,645</b>	<b>819,528</b>
<b>Нийт</b>				<b>11,401,645</b>	<b>3,053,239</b>

Тэмдэглэл: ХХБ-д 67402.67 төгрөгийн, 220.52 ам.долларын үлдэгдэл бүхий харилцах данстай байна.

### 5. Татварын авлага

Үзүүлэлт	Валют	Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Хасагдсан	Эцсийн үлдэгдэл
ААНОАТ-ын авлага	MNT	1,945,498	-		1,945,498
НӨАТ-ын авлага	MNT	1,733,825	207,684		1,941,509
<b>Нийт</b>		<b>3,679,323</b>	<b>207,684</b>		<b>3,887,007</b>

### 6. Бусад авлага

Үзүүлэлт	Валют	Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Хасагдсан	Эцсийн үлдэгдэл
Холбоотай талаас авах авлага	MNT	268,837,420	33,400,000		302,237,420
<b>Нийт</b>		<b>268,837,420</b>	<b>33,400,000</b>		<b>302,237,420</b>

Тэмдэглэл: Эм Ди Ки Ай ХХК 280 237 420 төгрөг, -Аката Тур ХХК-с 22 000 000 төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна.

### 7. Урьдчилж төлсөн зардал тооцоо

Үзүүлэлт	Валют	Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Хасагдсан	Эцсийн үлдэгдэл
Урьдчилж төлсөн зардал	MNT	1,942,700	46,174,482		48,117,182
<b>Нийт</b>		<b>1,942,700</b>	<b>46,174,482</b>		<b>48,117,182</b>

Тэмдэглэл: Удирдлагын зардлын УГЗ дансанд бүртгэв

### 8. Үндсэн хөрөнгө

Үзүүлэлт	12/31/2022	Нэмэгдсэн	Хасагдсан	12/31/2023
Барилга байгууламж	162,037,000		62,500,000	99,537,000
Барилга байгууламжийн хуримтлагдсан элэгдэл	(20,317,800)		20,317,800	
<b>Үндсэн хөрөнгийн дүн</b>	<b>141,719,200</b>		<b>42,182,200</b>	<b>99,537,000</b>

Хавсаргасан тэмдэглэлүүд нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно.



## 9. Биет бус хөрөнгө

Үзүүлэлт	12/31/2022	Нэмэгдсэн	Хасагдсан	12/31/2023
Програм хангамж	159,800			159,800
Програм хангамж /хорогдуулга/		(51,634)		(51,634)
<b>Биет бус хөрөнгийн дүн</b>	<b>159,800</b>	<b>(51,634)</b>	<b>-</b>	<b>108,166</b>

## 10. Урт хугацаат хөрөнгө оруулалт

Үзүүлэлт	Валют	Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Хасагдсан	Эцсийн үлдэгдэл
УХХО	MNT	3,741,971,580		36,900,000	3,705,071,580
<b>Нийт</b>		<b>3,741,971,580</b>		<b>36,900,000</b>	<b>3,705,071,580</b>

Тэмдэглэл: 1,139,284,100төг нь өмнөх эзэмшигчийн УХХО дүн бөгөөд 2,565,787,480 төг нь Альфа доктор мед ХХД-д оруулсан хөрөнгө оруулалт хийсэн байна.

## 11. Татварын өглөг

Үзүүлэлт	Валют	Эхний үлдэгдэл	Хасагдсан	Нэмэгдсэн	Эцсийн үлдэгдэл
ХХОАТ өглөг	MNT	111,762		662,343	774,105
<b>Нийт</b>		<b>111,762</b>		<b>662,343</b>	<b>774,105</b>

## 12. Богино хугацаат өр төлбөр

Үзүүлэлт	Валют	Эхний үлдэгдэл	Хасагдсан	Нэмэгдсэн	Эцсийн үлдэгдэл
Банкны богино хугацаат зээл	MNT	101,772,424		26,568,780	128,341,204
		101,772,424		26,568,780	-
					128,341,204
					0

Тэмдэглэл: Ли захирлаас богино хугацаанд хүүгүй зээлсэн мөнгө

## 13. Богино хугацаат зээл

Үзүүлэлт	Валют	Эхний үлдэгдэл	Хасагдсан	Нэмэгдсэн	Эцсийн үлдэгдэл
Их бараат ХХК	MNT	25,000,000	21,000,000		4,000,000
<b>Нийт</b>		<b>206,179,633</b>	<b>85,655,943</b>	<b>0</b>	<b>120,523,691</b>

## 14. Урт хугацаат өр төлбөр

Үзүүлэлт	Валют	Эхний үлдэгдэл	Хасагдсан	Нэмэгдсэн	Эцсийн үлдэгдэл
Урт хугацаат хөрөнгө зээл		2,847,235,882			2,847,235,882
<b>Нийт</b>		<b>2,847,235,882</b>			<b>2,847,235,882</b>

## 15. Эздийн өмч

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
Хувьцаат капитал	1,373,575,194	1,373,575,194
Халаасны хувьцаа	3,269,700	3,269,700

Хавсаргаасан тэмдэглэлүүд нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно.



Эздийн өмчийн бусад хэсэг	1,029,200	1,029,200
Хуримтлагдсан ашиг/алдагдал	(151,232,794)	(193,515,583)
<b>Нийт</b>	<b>1,226,641,2,300</b>	<b>1,184,358,511</b>

#### 16. Гадаад валютын ханшийн зөрүүний олз /гарз/

Үзүүлэлт	2022	2023
Ханшийн зөрүүний олз /гарз/	3,513,600	(100,900)
<b>Нийт</b>	<b>3,513,600</b>	<b>(100,900)</b>

#### 17. Бусад зардал

Үзүүлэлт	2022	2023
Хүлээн авалт, баяр ёслолын зардал	14,551,300	
<b>Нийт</b>	<b>14,551,300</b>	

#### 18. Татварын зардал

Үзүүлэлт	2022	2023
Орлогын албан татварын зардал		35
<b>Нийт</b>		<b>35</b>

#### 19. Ерөнхий удирдлагын зардал

Үзүүлэлт	2022	2023
Ажиллагчдын цалингийн зардал	25,652.7	
Аж ахуйн нэгжээс төлсөн НДШ-ийн зардал	3,198.0	
Албан татвар, төлбөр, хураамжийн зардал	1,760.4	
Томилолтын зардал	8,496.6	
Бичиг хэргийн зардал	439.7	
Шуудан холбооны зардал	311.7	
Мэргэжлийн үйлчилгээний зардал	7,927.3	
Засварын зардал	163.1	
Шатахууны зардал	3,119.2	
Зар сурталчилгааны зардал	363.6	
хангамж	3,609.2	
Банкны шимтгэл	72.0	
Бусад	1,635.0	
<b>Нийт</b>	<b>56,749</b>	

#### 20. Балансын дараах үйл явц

2023 оны 02 сарын 18-ний байдлаар “Жидакс” ХК-ийн санхүүгийн тайланд материаллагаар нөлөөлөхүйц ямар нэгэн үйл явдал болоогүй байна.

ГОЛДЕН ПЭЙЖ АУДИТ ХХК

Хавсаргасан тэмдэглэлүүд нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно.

